

БАЯНТАЛ СУМЫН 2024 ОНЫ 11 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

2024.11.25

Баянтал сум

Нэг. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Сумын удирдах ажилтны шуурхай хурлыг 1 удаа, дотоод хурлыг 7 хоног болгоны 1 өдөр хуралдаж үүрэг даалгаврыг сумын Засаг дарга болон, ЗДТГ-н дарга нараас өгсөн төрлийн үүрэг даалгаврыг тухай бүр хариуцсан албан хаагчдад дамжуулан өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Цахим мэдээлэл: “Говьсүмбэр аймгийн Баянтал сум” фэйсбүүк групп хуудсанд нийт 17 мэдээлэл оруулсан үүний 8 ведио, 9 зурган мэдээлэл байна. Аймгийн хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол шэйр хийж түгээж ажилласан байна.

Мөн Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 3 шейрлэж ажилласан.

Төрийн үйлчилгээний ХУРДАН цэгээс <https://operator.e-mongolia.mn/dashboard> системээр 10 сарын 25 наас 11 сарын 25-ны хүртэл нийт 8 лавлагаа мэдээлэл гаргаж ажилласан. Үүнээс:

- ❖ Иргэний үнэмлэхийн лавлагаа – 5
- ❖ Оршин суугаа хаягын тодорхойлолт - 1
- ❖ Гэрлэсний бүртгэлийн лавлагаа – 1
- ❖ Мал тооллогын лавлагаа – 1

Хоёр. ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Шилэн данс: Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 10 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 11 дүгээр сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 85 хувьтай байна.

10 дугаар сарын орлого:

1. Говьсүмбэр, Баянтал Суутган 5,029,237.46
2. Говьсүмбэр, Баянтал Хувь хүний АТ- 43,500.00
3. Говьсүмбэр, Баянтал Газрын төлбөр 42,196.00
4. Говьсүмбэр, Баянтал ҮХЭХАТ- 1,407,840.00
5. Говьсүмбэр, Баянтал Улсын тэмдэгтийн хураамж 285,250.00
6. Говьсүмбэр, Баянтал малын тоо толгой албан татвар 520,000.00
7. Говьсүмбэр, Баянтал иргэн ҮХХБАТ 169,200.00
8. Говьсүмбэр, Баянтал Хадгаламжийн хүү орлого 458,292.05
9. Говьсүмбэр, Баянтал Галт зэвсэг 30,000.00
10. Г.с.Ба Хог хаягдлын хураамж 50,000.00

Нийт: 8,035,515.51

Дөрөв. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

2024 оны 11 сарын 15нд сумын Аюулгүй нөөцөнд 1475 боодол өвсийг ангорт хурааж ажилласан.

Жилийн эцсийн мал тооллого явагдахтай холбоотойгоор багийн Засаг дарга нар, санхүү албаны дарга, ХАА-н мэргэжилтэнүүд аймаг дээр сургалтанд сууж ажилласан.

Сумын ИТХурлаар “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох тов зарлуулж 2 төсөл ирсэнг төсөл хүлээн авах ажлын хэсэг холбогдох материалтай танилцсан боловч шаардлага хангаагүй тул буцаагдсан.

Мал эмнэлэг: Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 68 өрхийн 2139 үхэр, Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 62 өрхийн 15190 хонь, хурга, мөн 8 сарын 15-нөөс эхлэн угаалгын явцад 20 гаран өрх хамрагдсан. 10 сард бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 37 өрхийн хонь 70783, ямаа 850, нийт 71633 толгой мал хамрагдсан байна.

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний чиглэлээр:

Баянтал сумын Амьжиргаа дэмжих зөвлөл нийт 3 удаа хуралдсан. энн зөвлөлийн хурлаар: 1. Байнгын асаргаа шаардлагатай өндөр настныг асарч байгаа мөнгөн тэтгэмжид-2, 2. Олон нийтийн оролцоонь түшиглэсэн Сэргээн засах үйлчилгээнд 9 иргэн, 3. Нийгмийн халамжийн сангийн бүлгийн төсөлд 2 төсөл. Нийт 14 иргэний асуудлыг шийдвэрлэж тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээнд хамруулан ажилласан байна

ТАВ. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Гамшгаас хамгаалах чиглэлээр:

2024 оны 11 сарын 13 нд Улсын Онцгой байдлын газраас 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирж Баянтал суманд Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, дадлага сургуулилт болж амжилттай оролцсон. Онцгой байдлын ерөнхий газраас ирсэн ажлын хэсэг “Хангалттай” гэсэн үнэлэлт дүгнэлт өгсөн.

Баянтал сумын 2024 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр

2024 оны 11-р сарын 25-ны өдрийн байдлаар ОНХС-гийн үйл ажиллагаагаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах зардлаас Нью хархорин тэйрэм ХХК-тай 1,221,000 төгрөгөөр 3 хос буюу 6 ширхэг богино долгион дамжуулах гар станц худалдан авсан.
2. Сумын өвс тэжээл нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд Малын тоо толгойн албан татварын орлогоос 867 боодол өвсийг Шударга-үйлс ХХК-тай 9,970,500 төгрөгөөр гэрээ байгуулан худалдан авсан.
3. Сумын өвс тэжээл нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр 608 боодол өвсийг Шударга-үйлс ХХК-тай 6,992,000 төгрөгөөр гэрээ байгуулан худалдан авсан.
4. Соёлын төв Ёс заншлын өргөөтэй болох ажлын хүрээнд 8 ханатай сийлбэртэй гэрийн мод нийлүүлэх 20,000,000 төгрөгийн гэрээ байгуулсан.
5. Соёлын төв Ёс заншлын өргөөтэй болох ажлын хүрээнд 8 ханатай гэрийн дээвэр, туурга, бүрээс иж бүрдэл нийлүүлэх 20,000,000 төгрөгийн гэрээ байгуулсан.
6. Спорт заалны барилга угсралтын ажил дууссан тул хүлээн авах комисс томилж өгнө гэсэн албан тоот бичгийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.

БАЯНТАЛ СУМ